



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2017 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 03

Номгон

2017 онд хувьчлах, худалдах  
хөрөнгийн тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, “б” дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.3 дахь заалтуудыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2011 онд ашиглалтад орсон 16-86 БНХ улсын дугаартай Toyota-Land 450 маркийн автомашины худалдах доод үнийг 7,0 сая төгрөгөөр тогтоож дуудлагаар худалдсугай.

2. Эрдэнэцогт сумд 2014 онд ашиглалтад орсон 196500,0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 13100,0 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан дулааны шугам сүлжээний хувьчлах доод үнийг мэргэжлийн үнэлгээчин болон үнэлгээний компаниар зах зээлийн үнэнд нийцүүлэн бодитой тогтоолгож 2017 оны 05 дугаар сард багтаан хувьчилсугай.

3. Аймгийн Засаг дарга Г.Батжаргалд ДААЛГАХ нь:

3.1 Хувьчлах дулааны шугам сүлжээний зориулалтыг нь өөрчлөхгүйгээр хууль журмын дагуу ажлын хэсэг байгуулан төсөл сонгон шалгаруулах аргаар зохион байгуулж, хувьчилсан тухай тайлангаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд II улиралд багтаан танилцуулсугай.

3.2 Хувьчилсан дулааны шугам сүлжээний орлогыг Эрдэнэцогт сумын Төрийн сан банкин дахь Бх.Эрдэнэцогт ОНХ сан **100030352400** тоот дансанд төвлөрүүлж, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 4-129-д заасан ажил, арга хэмжээнд зарцуулсугай.

4. Автомашины дуудлага худалдаа явуулах комисс томилон, хууль журмын дагуу 2017 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 11 цагт Эрдэнэцогт сумын иргэний танхимд зохион байгуулж орлогыг тус сумын Төрийн сан банкин дахь Бх.Эр

116099

ОНЕрөнхий орлого 100030300910 тоот дансанд төвлөрүүлэхийг сумын Засаг дарга /Ц.Төмөрбаатар/-д даалгасугай.

5. Хувьчилсан, худалдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих журмын дагуу хийхийг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ч.Мөнхцэцэг/-д даалгасугай.

6. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА  Ц.ОТГОНБАЯР